

БАТЛАВ: САЙХАН СУМЫН ЗАСАГ

ДАРГА

М.ГАНБОЛД

**ТАМГЫН ГАЗАРТ КОМПЬЮТЕР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
ХУДАЛДАН АВАХ ҮНИЙН САНАЛ АВАХ**

(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХ)

САЙХАН СУМ

2019 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 99344477, 88090218

Web: <https://www.tender.gov.mn/>

**ТАМГЫН ГАЗАРТ КОМПЬЮТЕР ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: ТАМГЫН ГАЗАРТ КОМПЬЮТЕР ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ АВАХ

Харьцуулалт/ гэрээний
дугаар: СА20190412

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

САЙХАН СУМ ЗДТГазар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **КОМПЬЮТЕР ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ** –ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 4 сарын 18 өдрийн 15 цаг 30 минут** -аас өмнө **Булган аймгийн Сайхан сумын ЗДТГазрын Санхүүгийн Албаны өрөөнд /2 давхарт/** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 4 сарын 18-** ны өдрийн **15 цаг 40 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

БУЛГАН АЙМАГ САЙХАН СУМ ЗДТГ
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ӨРӨӨ 99344477, 88090218

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **3** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан</p> <p>Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага; туслан гүйцэтгэгч оролцохгүй</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: компьютер хэрэгсэл худалдан борлуулах тусгай зөвшөөрөл</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Булган аймаг Сайхан сум 5-р баг ЗДТГ 2 давхар байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: ЗДТГ 2 давхарт Санхүүгийн албаны өрөө</p> <p>Огноо: 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: : Булган аймаг Сайхан сум 5-р баг ЗДТГ 2 давхар байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар ЗДТГ 2 давхарт Санхүүгийн албаны өрөө</p> <p>Огноо: 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 1 багц компьютер иж бүрдэл</p>

БАТЛАВ: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С. ЛУВСАНЦООДОЛ

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

№	Барааны нэр	Үзүүлэлт	Тоо шир хэг
1	Ширээний компьютер	<ul style="list-style-type: none"> • Үйлдлийн Систем / OS: Windows 10 Home 64-bit • Процессор / CPU: Intel® 8th Generation Core™ i5-8400 (9M Cache, 4.0 GHz) • Шуурхай санах ой / RAM: 4GB DDR4 2666MHz (up to 32GB) • Хатуу диск / HDD: 1TB 7200 rpm SATA 3Gb/s Hard Drive <ul style="list-style-type: none"> • График карт: Intel® HD Graphics 630 • Оптик драйв: Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD) <ul style="list-style-type: none"> • Сүлжээ: Integrated Giga bit 10/100/1000 Ethernet • Wireless: Wireless™ 1707 Card (802.11BGN + Bluetooth 4.0, 2.4 GHz) <ul style="list-style-type: none"> • Multimedia Keyboard-KB216 MS116 Wired Mouse Black • Оролт гаралтууд: <ul style="list-style-type: none"> • Front (2) USB 3.0, (1) Universal Audio Jack • Rear (4) USB 2.0 RJ-45 HDMI VGA 3-stack audio jacks supporting 5.1 surround sound (2) PCIe x 1, PCIe x 16, PCI (3653 only) <ul style="list-style-type: none"> • Power Supply Unit: 290W PSU (EPA Bronze – Full range) • Хэмжээ (эндэр): мм Гүнс мм Өргөн: мм Жин: кг <ul style="list-style-type: none"> • Баталгаа - 1 жил 	2ш
2	Зөөврийн компьютер	<ul style="list-style-type: none"> • Үйлдлийн систем / OS: Windows 10 Home 64-bit • Процессор / CPU: 8th Generation Intel® Core™ i5-8250U Processor (6MB Cache, up to 3.4 GHz) • Шуурхай санах ой / RAM: 4GB, 2400MHz, DDR4; up to 16GB (additional memory sold separately) • Дэлгэц / Display: 15.6-inch FHD (1920 x1080) Anti-Glare LED-Backlit Display <ul style="list-style-type: none"> • График: AMD Radeon™ 520 Graphics with 2GB GDDR5 • Багтаамж / HDD: 1TB 5400 rpm Hard Drive • CD/DVD уншигч: Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD) • Интерфэйс: 1 10/100 RJ-45 Ethernet network 1 HDMI v1.4a 2 USB 3.1 gen 1 1 USB 2.0 1 Kensington Lock • Media Card Reader: Kensington lock slot, SD card (SD, SDHC, SDXC) • Audio and Speaker: 2 tuned speakers with Waves MaxxAudio® Pro 1 combo headphone / microphone jack • Камер / Микрофон: Integrated widescreen HD (720p) Webcam with Dual Digital Microphone • Wireless / Утасгүй сүлжээ: 802.11ac + Bluetooth 4.1, Dual Band 2.4&5 GHz, 1x1 <ul style="list-style-type: none"> • Баттерэй: 40 Whr, 4-Cell Battery (removable) • Хэмжээ: Height: 0.93" (23.65 mm) x Width: 14.96" (380 mm) x Depth: 10.25" (260.3 mm) <ul style="list-style-type: none"> • Жин: 2.13кг • Баталгаа - 24 сар 	9ш

<p>3</p> <p>Принтер /өнгөт/</p>	<ul style="list-style-type: none"> • Хэвлэх, хувилах, сканнердах үйлдэлтэй <ul style="list-style-type: none"> • Хэвлэлт: On-demand ink jet (piezoelectric) 4-colour • Хэвлэх нягтрал хамгийн ихдээ: 5760x1440 dpi (with VSDT) <ul style="list-style-type: none"> • Хэвлэх хурд: <ul style="list-style-type: none"> • А4 текст (драфт) дунджаар 33/15ppm (хар/өнгөт) • Фото (default) - 10x15cm/4x6" дунджаар 69 сек (хүрээтэй) • Хувилах, үргэлжлүүлэн хувилах: 20 Илэсгэж багаарах: 25-400%, Auto Fit Function <ul style="list-style-type: none"> • Сканнердах Нягтрал: 600 dpi x 1,200 dpi <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: 216 x 297mm (8.5 x 11.7") • Хурд: Дунджаар 11 сек (хар 300dpi) Дунджаар 28 сек (өнгөт 300dpi) • Хэвлэх цаасны хэмжээ: А4, А5, А6, В5, 10x15cm(4x6in), 13x18cm(5x7in), 9x13cm(3.5x5in), Letter(8 1/2x11in), <ul style="list-style-type: none"> • Legal(8 1/2x14in), Half Letter(5 1/2x8 1/2in), 13x20cm(5x8in), 20x25cm(8x10in), 16:9 • wide size, 100x148mm, Envelopes: #10(4 1/8x9 1/2in), DL(110x220mm), C6(114x162mm) • Орох цаас: 100/20 хуудас (A4 Plain paper/Premium Glossy Photo Paper) • Гарах цаас: 30/20 хуудас (A4 Plain paper/Premium Glossy Photo Paper) <ul style="list-style-type: none"> • Хүрээтэй хэвлэнэ: Цаасны захаас 3мм • Холболт / Connectivity: USB 2.0 Hi-Speed, Wi-Fi IEEE 802.11b/g/n, Wi-Fi Direct <ul style="list-style-type: none"> • Тохирох үйлдлийн систем: <ul style="list-style-type: none"> • Windows XP / XP Professional x64 Edition / Vista / 7 / 8 / 8.1 • Mac OS X 10.6.8, 10.7.x, 10.8.x, 10.9.x • Тохирох хор: <ul style="list-style-type: none"> • Хар: T00V100 (дунджаар 4,500 хуудас) A4 plain paper • Цэнхэр: T00V200 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper • Ягаан: T00V300 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper • Шар: T00V400 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper • Хэмжээ: 482 x 300 x 145 мм • Жин: 3,9 кг • Баталгаа: 6 сар 	<p>1ш</p>
<p>4</p> <p>Принтер /хар цагаан/</p>	<ul style="list-style-type: none"> • Хэвлэх, хар, цагаан <ul style="list-style-type: none"> • Хэвлэлт: On-demand ink jet (piezoelectric) 4-colour • Хэвлэх нягтрал хамгийн ихдээ: 5760x1440 dpi (with VSDT) • Хэвлэх хурд: А4 текст (драфт) дунджаар 33/15ppm (хар/өнгөт) <ul style="list-style-type: none"> • Фото (default) - 10x15cm/4x6" дунджаар 69 сек (хүрээтэй) • Хэвлэх цаасны хэмжээ: А4, А5, А6, В5, 10x15cm(4x6in), 13x18cm(5x7in), 9x13cm(3.5x5in), Letter(8 1/2x11in), <ul style="list-style-type: none"> • Legal(8 1/2x14in), Half Letter(5 1/2x8 1/2in), 13x20cm(5x8in), 20x25cm(8x10in), 16:9 • wide size, 100x148mm, Envelopes: #10(4 1/8x9 1/2in), DL(110x220mm), C6(114x162mm) <ul style="list-style-type: none"> • Орох цаас: 100/20 хуудас (A4 Plain paper) • Гарах цаас: 30/20 хуудас (A4 Plain paper) • Хүрээтэй хэвлэнэ: Цаасны захаас 3мм • Холболт / Connectivity: USB 2.0 Hi-Speed, Wi-Fi IEEE 802.11b/g/n, Wi-Fi Direct <ul style="list-style-type: none"> • Тохирох үйлдлийн систем: Windows XP / XP Professional x64 Edition / Vista / 7 / 8 / 8.1 Mac OS X 10.6.8, 10.7.x, 10.8.x, 10.9.x • Тохирох хор: Хар: T00V100 (дунджаар 4,500 хуудас) A4 plain paper Цэнхэр: T00V200 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper Ягаан: T00V300 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper Шар: T00V400 (дунджаар 7,500 хуудас) A4 plain paper <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: 482 x 300 x 145 мм • Жин: 3,9 кг • Баталгаа: 6 сар 	<p>1ш</p>

2. Стандарт: Монгол улсын стандарт дүрэм журамд нийцсэн байна.
3. Баглаа, боодол: Тоног төхөөрөмжийг зориулалтын хайрцагт боож багласан байна. Мөн дээр нь хагарах эвдрэх зэрэг аюултайг мэдээлсэн байна.
4. Бараа хүргэх газар: Булган аймаг Сайхан сум 5-р баг ЗДТГ байр
5. Зураг: 4 талаас авсан зурагтай байна.

Боловсруулсан: Нягтлан бодогч *М.М.М.* М.Мөнхтөр

Хянасан: Төсвийн мэргэжилтэн *Б.Бүжинлхам* Б.Бүжинлхам

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлагатай .</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн 30% хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: хоногийн 0,5%</p> <p>Алдангийн нийт дүн: 1000000 сая төгрөг</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]